

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

#### Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан  
шинэчлэн боловсруулсан  
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.12.27

#### Байгууллагын нэр:

Тээврийн цагдаагийн алба

#### Нэгжийн нэр:

Замын цагдаагийн газрын Замын хөдөлгөөний  
удирдлагын хэлтэс

#### Албан тушаалын нэр:

Хэлтсийн дарга

#### Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-3

#### Ажлын цаг:

8 цаг

#### Ажлын байрны албан ёсны байршил:

Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороо, Бага тойруу  
гудамж, Нийслэлийн төр захиргааны IV байр

#### Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

#### Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гол түймэр, хүн, малын гоц  
халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад аюул  
тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал  
үүссэн, террорист халдлага, онц болон дайны  
байдал зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн  
зэрэг зайлшгүй тохиолдолд өндөржүүлсэн бэлэн  
байдалд ажиллах.

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

#### Албан тушаалын зорилго:

Замын хөдөлгөөнд оролцогчийн хэвийн, аюулгүй зорчих нөхцөлийг бурдүүлэх зорилгоор замын  
хөдөлгөөн зохицуулах ажлыг нийслэлийн хэмжээнд төлөх хяналтын системээр удирдан зохион  
байгуулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, журмын зөрчлийг автомат  
ажиллагаатай хэмжилт-хяналтын төхөөрөмж ашиглан баримтжуулах, бэлэн бус хэлбэрээр  
шийтгэл оногдуулах, замын хөдөлгөөнийг зохицуулахтай холбогдсон үйл ажиллагааг  
боловсронгуй болгох, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад мэргэжил арга зүйн туслалцаа  
үзүүлэх;

## Албан тушаалын зорилт:

1. Замын хөдөлгөөн зохицуулах ажлыг нийслэлийн хэмжээнд төлөхяналтын системээр удирдан зохион байгуулах, замын хөдөлгөөнийг зохицуулахтай холбогдсон үйл ажиллагааг боловсронгуй болгох, хэлтсийн үйл ажиллагааг удирдах.
  2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, журмын зөрчлийг автомат ажиллагаатай хэмжилт-хяналтын төхөөрөмж ашиглан баримтжуулах, бэлэн бус хэлбэрээр торгууль оногдуулах, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх.
  3. Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах –Т, Харилцан, гүйцэтгэх –Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд:	<p>1.1. Нийслэлийн хэмжээнд замын хөдөлгөөнд оролцогчийн хэвийн, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Замын хөдөлгөөний удирдлагын төвийн гэрлэн дохио, камерын тусламжтайгаар гудамж замын хөдөлгөөнийг удирдан зохион байгуулах;</p> <p>1.2. Замын хөдөлгөөнийг зохицуулах, ургсал, чиглэлийг өөрчлөх, хөдөлгөөнийг түр хаах, хязгаарлахтай холбоотой стандарт, дүрэм, журам, заавар, зөвлөмжийн хэрэгжүүлэх;</p> <p>1.3. Замын хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэл /гэрлэн дохио, камер, хэрэгсэл/-ийн хэвийн ажиллагаанд хяналт тавьж, зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэж, зөрчлийг арилгуулах хууль, тогтоомжид заасан арга хэмжээг хэрэгжүүлэх;</p> <p>1.4. Эрх бүхий байгууллагаас хамгаалалт зохион байгуулах, байгалийн гамшиг, онцгой нөхцөл үүссэн үед хөдөлгөөнд оролцогчдын хэвийн, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Улаанбаатар хотын хэмжээнд замын хөдөлгөөн зохицуулах ажилд техник хэрэгсэл ашиглаж туслалцаа үзүүлэх, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах;</p> <p>1.5. Улсын хэмжээнд эрэн сурвалжлагдаж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд тусгай төхөөрөмж ашиглан хяналт тавих, илрүүлэх, мэдээлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах, энэ чиглэлээр нутаг дэвсгэрийн цагдаагийн</p>	Замын хөдөлгөөний зохицуулалт, хамгаалалтын үйл ажиллагаа сайжирсан байна.	Г, Х Г, Х Г, Х Г, Х Г, Х Г, Х Г, Х

	<p>байгууллагад дэмжлэг үзүүлэх, харилцан ажиллах;</p> <p>1.6.Замын хөдөлгөөн зохицуулах зорилгоор тээврийн хэрэгслийг зөёж шилжүүлэх ажиллагааг нийслэлийн хэмжээнд хариуцаж, шаардлагатай мэдээллээр хангах, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах;</p> <p>1.7.Замын хөдөлгөөнийг зохицуулах, тусгай төхөөрөмж ашиглан хяналт тавих үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх, гадаад орнуудын туршлагыг судлах, хамтын ажиллагааг өргөжүүлэх;</p> <p>1.8.Хэлтсийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, байгууллагын дотоод журмыг мөрдүүлэх, хяналт тавих;</p> <p>1.9.Алба хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, биелэлтэд хяналт тавих;</p> <p>1.10.Харья хэлтсийн болон алба хаагчийн үйл ажиллагаа, сахилга, ёс зүйн зерчлийн талаар гаргасан өргөдөл, гомдолд холбогдох журмын дагуу дотоод хяналт шалгалт зохион байгуулах, сахилга, ёс зүйн зерчлийг шалгаж тогтоох, үнэлэлт, дүгнэлт өгч илэрсэн зерчил дутагдлыг арилгуулах;</p> <p>1.10.Хэлтсийн алба хаагчдын мэдлэг, ур чадвар, бие бялдрын хөгжил, сахилга, ёс зүй, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, хүний эрх, эрх чөлөө зөрчих, авилгаас урьдчилан сэргийлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах нөхцөл бололцоог хангахад чиглэсэн ажлуудыг зохион байгуулах;</p>	Г, Х Г,Х Г,Х Г,Х Г,Х
2 дугаар зорилтын хүрээнд	<p>2.1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд автомат ажиллагаатай хэмжилт-хяналтын төхөөрөмж ашиглан зерчил илрүүлэх, бэлэн бус хэлбэрээр шийтгэл оногдуулах ажлыг нийслэлийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх;</p> <p>2.2.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор замын хөдөлгөөн зохицуулах, бэлэн бус шийтгэл оногдуулахтай холбоотой асуудлаар шаардлагатай мэдээ, мэдээллийг боловсруулж, дээд шатны байгууллага, албан тушаалтанд танилцуулах, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;</p> <p>2.3.Замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой зөрчлийг тусгай төхөөрөмж ашиглан илрүүлэх, хяналт тавих үйл ажиллагааны эрх зүйн орчныг</p>	Г, Х Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх нөхцөл боломж сайжирсан байна. Г, Х Г, Х

	<p>боловсронгуй болгох стандарт, дүрэм, журам, заавар, зөвлөмжийг боловсруулах, холбогдох байгууллагад санал танилцуулах;</p> <p>2.4. Нийслэлийн хэмжээнд замын хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохио, төле камер, зөрчил илрүүлэх техник, хэрэгслийн ашиглалтад тавих;</p>		
	<p>3.1. Улсын Их Хурал, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Тээврийн цагдаагийн алба, харьяа нутаг дэвсгэрийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаас гаргасан хууль тогтоомж, захирамж, тогтоол, тушаал шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөө, үүрэг, ажлын чиглэл, албан даалгавар, заавар, зөвлөмжийг хэлтсийн хэмжээнд зохион байгуулан хэрэгжүүлж, биелэлт, үр дүнг тооцох, тайлagnах;</p> <p>3.2. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд цагдаагийн бусад нэгжтэй хамтран ажиллах;</p> <p>3.3.Хэлтсийн үйл ажиллагааны чиглэлээр шаардлагатай мэдээ, мэдээллийг боловсруулж, дээд шатны байгууллага, албан тушаалтанд танилцуулах, бусад байгууллагыг мэдээллээр хангах;</p> <p>3.4.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, шууд удирдах даргаас хариуцуулсан үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажиллах;</p> <p>3.5.Тээврийн цагдаагийн албаны болон хэлтсийн дотоод журмыг мөрдүүлж, алба хаагчдын болон байтууллагын аюулгүй байдлыг хангах, өмч, эд хөрөнгө, тусгай хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, зарцуулалт, ашиглалтад хяналт тавих ажлыг зохион байгуулах;</p> <p>3.6.Авлига, хүнд суртлаас ангид байж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, шударга ёсыг эрхэмлэн “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг чанд мөрдөх, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгээ тогтоосон хугацаанд үнэн, зөв мэдүүлэх, явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах;</p> <p>3.7.Авлигын сэжигтэй тохиолдол бүрийг холбогдох албан тушаалтан, байгууллагад мэдээлэх;</p> <p>3.8.Байгууллага, алба хаагч бусад ажиллагсдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр</p>		Г, Х
			Г, Х
			Г, Х
			Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд		Хэлтсийн үйл ажиллагаа хэвийн явагдах нэхцэл бүрдсэн байна.	Г, Х
			Г
			Г

	хэрэгжүүлэх ажилд бүх талын тусламж үзүүлэх.	
--	---	--

### III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Дээд боловсролтой, Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.	
Мэргэжил	Эрх зүйч /0421/, Аюулгүй байдал судлал /103901/, Иргэн, өмч хөрөнгө хамгаалал /1032/, Авто инженерчлэл /071601/.	
Мэргэшил	Албан тушаалын мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.	
Туршлага	Цагдаагийн байгууллагад 12-оос доошгүй жил ажилласан, үүнээс чиглэлийн ахлах, хэсэг, тасгийн даргын албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх.	
Үр чадвар	Удирдан зохион байгуулах	-Хариуцсан ажлаа төлөвлөх, зохион байгуулах; -Удирдлагадаа байгаа албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдах чадвартай; -Албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, зохих заавар чиглэл өгөх.
	Дүн шинжилгээ хийх	-Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулж, дүгнэх; -Шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг дүгнэх.
	Асуудал шийдвэрлэх	-Албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх.
	Манлайлах	-Ёс зүйгээр хамт олноо манлайлан үлгэр дуурайл үзүүлэх; -Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; -Байгууллагын үйл ажиллагааны шинэгээлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх.
	Бусад	-Ажил гүйцэтгэх, хэрэгжүүлэх; -Албан хэрэг хөтлөлт боловсруулах, монгол хэл, бичгийн дүрэм, үг зүй, найруулга зүйн зохих мэдлэгтэй байх; -Англи, орос хэлний анхан шатны мэдлэгтэй байх; -Компьютерын Microsoft Office Word, Excel, Power Point программуудыг хэрэглээний түвшинд ашиглах чадвартай байх.

### IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЬЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын дарга

Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо: Батлагдсан орон тоо.	Бусад харилцах субъект: Шууд харилцах байгууллага: Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан; Шууд бус харилцах байгууллага: Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэн; /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална./
---	--

**V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:**

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА  T.GANZORIG	Байгууллагын нэр: ..... Шийдвэрийн огноо: ..... Дугаар: .....
2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр	
<b>Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:</b>	
Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр. Дугаар: 8/нон	 ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

**Танилцсан:**

Албан тушаалтан..... .....
20... оны .... дугаар сарын ....-ны өдөр